

**“НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ДОЛОО ХОНОГ-2025”
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭН ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН**

2025.06.19

Улаангом

Увс аймгийн Засаг даргын Тамгын газар “Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног – 2025” арга хэмжээг “Бизнес ба хүний эрх” уриан дор **“Авлига”, “Иргэний орон зай”, “Олон нийтийн оролцоо”** сэдвүүдийн хүрээнд 2025 оны 5 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээ нь орон нутгийн бизнес эрхлэгчдэд мэдээлэл хүргэх, **e-business.mn** платформыг таниулах, уг системээр дамжуулан цахим үйлчилгээг хэрхэн авах талаар мэдээлэл олгох, улмаар тэдний цахим боловсролыг дэмжих зорилготой байв.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн ХЭГ/1122 дугаар албан бичгээр ирүүлсэн “Нээлттэй засгийн түншлэлийн 7 хоног – 2025” арга хэмжээг зохион байгуулах жишиг удирдамжийн хүрээнд орон нутагт арга хэмжээ зохион байгуулах ажлын хэсгийг Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн А/53 тоот тушаалаар байгуулсан.

Ажлын хэсгээс дараах үйл ажиллагааг зохион байгууллаа:

- Арга хэмжээг албан ёсоор эхлүүлж буй тухай олон улсын болон үндэсний уриалгыг багтаасан богино хэмжээний видео бичлэг, постер зэргийг орон нутгийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэсэн;
- **e-business.mn** платформыг хөгжүүлэгч “И-Монгол Академи” УТҮГ-тай хамтран уг платформын албан ёсны танилцуулга, видео контент, постер зэрэг материалыг цахим хуудсаар нийтэлж, мөн танилцуулга бүхий тараах материалыг бэлтгэн бизнес эрхлэгчдэд түгээсэн;
- 2025 оны 5 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд ажлын хэсгийн гишүүд 252 бизнес эрхлэгчийн ажлын байранд очиж **e-business.mn** платформын талаарх ойлголтын түвшинг тодорхойлох тандалт судалгаа хийсэн;
- Засаг даргын Тамгын газрын нийт албан хаагчид болон төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагын удирдлагуудад “Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног-2025” арга хэмжээ, холбогдох нэр томъёо, баримт бичгүүдийн талаар сургалт, мэдээлэл өгсөн;
- 2025 оны 5 дугаар сарын 19-нд “Ойрад” ХЖТеатрт бизнес эрхлэгчдийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, дараах агуулгын хүрээнд танилцуулга хийж, гарын авлага тарааж, зөвлөгөө өгсөн. Үүнд:
 - Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс 2011 онд баталсан **“Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд”**;

- Монгол Улсын Засгийн газраас баталсан “**Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө**”;
- **e-business.mn** платформын ашиглалтын явцад тулгарч буй хүндрэл, шийдлийн талаар санал солилцсон;
- Увс аймгийн 100 жилийн ойн хүрээнд бизнес эрхлэгчдийг цахим платформ ашиглан хэрхэн зохион байгуулалтад оруулах талаар хэлэлцэж, боломжуудыг тодорхойлсон.
- 2025 оны 5 дугаар сарын 21-нд алслагдсан сумдын бизнес эрхлэгчдэд зориулсан цахим сургалтыг зохион байгуулж, 37 бизнес эрхлэгч хамрагдсан;
- “Хариуцлагатай бизнесийн төлөөх залуус ба хэвлэл мэдээлэл” төслөөс санаачлан зохион байгуулсан “**Бизнес ба хүний эрх**” сэдэвт цахим сургалтад Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 26 агентлагийн холбогдох албан хаагчид ЗДТГ-ын 313 тоот танхимд нэгдсэн байдлаар хамрагдсан;
- Бизнес эрхлэгчдээс авсан тандалт судалгаа болон уулзалт, хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн 2025 оны 4 дүгээр улиралд Төрийн цахим үйлчилгээний хэлтсээр дамжуулан **e-business.mn** платформыг үргэлжлүүлэн сурталчлах, хэрэглээг нэмэгдүүлэх төлөвлөгөө боловсруулсан;
- Зохион байгуулсан үйл ажиллагааг **#OpenGovWeek, #OpenGovChallenge, #OGP, #OpenGov, #Mongolia, #OGPActionPlan, #DijitalUvsaimag** зэрэг хаштагуудыг ашиглан цахим орчинд түгээн сурталчилсан;
- Арга хэмжээний тухай мэдээллийг орон нутгийн телевиз, www.uvs.gov.mn сайт, “Увсын мэдээ” цахим хуудсаар олон нийтэд хүргэсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

“НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН 7 ХОНОГ-2025” АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ЗУРАГ, ТАЙЛБАР

1. “НЭЭЛТТЭЙ засгийн түншлэлийн 7 хоног” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг батлах, удирдамж.


УВС АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 14 өдөр Дугаар А/53 Улаанбаатар

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног-2025” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулоулай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Оюунбилэг (Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн дарга)

Нарийн бичгийн дарга: Г.Болортуулал (Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн мэргэжилтэн)

Гишүүд:

Б.Алтан (Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ийн дарга)

Д.Ганхуяг (Улаангом сумын ЗДТГ-ын дарга)

Сумдын ЗДТГ-ын дарга нар

Э.Наранмаадах (Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ийн мэргэжилтэн)

Ц.Магнайдүүрэн (Аймгийн ЗДТГ-ын СТОХ-ийн мэргэжилтэн)

Г.Тамир (Аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн мэргэжилтэн)

Э.Гончиг (Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн мэргэжилтэн)

Т.Төвсанаа (Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн мэргэжилтэн)

Ж.Бат-Оргил (Аймгийн ЗДТГ-ын ХШУХ-ийн мэргэжилтэн)

Х.Дэлгэрмаа (Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн мэргэжилтэн)

Ц.Батзүл (Аймгийн ЗДТГ-ын ХМА-ны дарга)

С.Төрмөнх (Аймгийн ЗДТГ-ын ХМА-ны ажилтан)

Я.Хонгорзүл (Хүний эрхийн комиссын Увс аймаг дахь салбарын референт)

Б.Ууганболор (Увс аймаг дахь ТЦҮХ-ийн үйлчилгээний ахлах ажилтан)

Г.Ариунболор (Увс аймаг дахь ТЦҮХ-ийн үйлчилгээний ажилтан)

Д.Цэцэбуяа (Татварын газрын хяналт, шалгалтын тасгийн дарга)

Э.Ганзориг (ХХҮГ-ын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл хариуцсан мэргэжилтэн)

Н.Ганчимэг (ХХААГ-ын үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний албаны дарга)

Ц.Бумбаяр (Эрчим хүчний хяналтын Улсын байцаагч)

Н.Ананд (Авто замын хяналтын Улсын байцаагч)

Х.Ганчимэг (Харилцаа холбооны хяналтын Улсын байцаагч)

2. Тус арга хэмжээг тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу өндөр түвшинд зохион байгуулж, үр дүн, тайланг 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн дотор холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэхийг ажлын хэсэг (С.Оюунбилэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА  У.ГАНЗОРИГ

D:\Arban bharitanga tushaal.docx
8525020404


Увс аймагын Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/53 тоот тушаалын хавсралт
“НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ДОЛОО ХОНОГ – 2025” арга хэмжээ

Үндэслэл: Монгол Улсын Засгийн газрын хэрэгт зориулж 2025.04.24-ны ХЭГ/1122 тоот албан бичиг.

Чиглэл: Харилцаатай бизнесийн үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлж, авлигын эсрэг тэмцлийг эрчимжүүлж, төрийн хэт оролцоо, хүнд суртлыг арилгах зорилгоор И-бизнес платформыг таниулан сурталчлах.

Сэтгэвч:

- “Бизнес ба хүний эрх”

Дэлгэс:

- Мэдээллийн хүртээмж (Мэдээлэл олж авах эрх зүйн орчны үр нөлөөг сайжруулах)

- Авлига (Авлигатай тэмцэх төрийн стратегийг, замын зурчлалыг боловсруулах, бэхжүүлэх)

- Олон нийтийн оролцоо (Төрийн бүхэл н дүвшинд зорилготой нийцсэн, хүргэмжтэй, олон нийтийн оролцоог нэвтрүүлэх)

Хүрэх үр дүн:

- Нээлттэй засаглалын түншлэлийн санаачилгыг танилцуулах, Нэгдсэн үндэсний байгууллагын “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд”-ын талаар мэдлэг ойлголт авах, “И-Бизнес” бизнес эрхлэгчид зориулсан платформыг ашигладаг болсон байна.

Төлөвлөсөн ажил:

Хугацаа	Арга хэмжээ	Хамрах хүрээ	Агуулга
2025.05.19 (Даваа)	Нээлттэй засгийн түншлэлийг таниулан сурталчлах, долоо хоногийн арга хэмжээ зохион байгуулах тухай өөрийн харьяа хэвлэл мэдээллийн сувгаар түгээж төлөвлөсөн арга хэмжээний тухай мэдээлэх	Иргэд, олон нийт, бизнес эрхлэгчид	Нээлттэй засгийн түншлэл, жил бүр 7 хоногийн арга хэмжээ зохион байгуулах, Монгол улс хэзээ хамрагдсан, НҮБ гэх мэт ойлголт өгөх.
2025.05.19 (Даваа)	Зах, худалдааны төвүүдээр явж бизнес эрхлэгчдээ урьдчилсан судалгаа авах	Бизнес эрхлэгчид	И-бизнес платформ ашигладаг эсэх талаарх судалгаа авна. Асуудлын тоо нөөц, агуулга цомхон байх.
2025.05.19 (Даваа)	Даваа гаригт 15:00 цагаас Ойрад ХЖТ-т Бизнес эрхлэгчдийн уулзалт	Бизнес эрхлэгчид	Бизнес эрхлэгчид дараах сэдвийн хүрээнд ойлголт өгөх. - Бизнес ба авлига

“НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ДОЛОО ХОНОГ – 2025” арга хэмжээний ажлын хэсгийн хуваарь

№	Нэр	Гишүүд	Чиг үүрэг
1	Контент	Х.Дэлгэрмаа Ц.Батзүл С.Төрмөнх	“Нээлттэй засаглалын түншлэл-2025” арга хэмжээ орон даяар зохион байгуулагдах байгаа... Манай аймаг ийм арга хэмжээ зохион байгуулна гэх мэт нээлттэй засаглал гэж юу вэ? гэдэг агуулга бүхий 2 контент “И Монгол академ” УТУГ, Төрийн шашин үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран И-бизнес платформын талаарх контент, танилцуулга бүхий богино хэмжээний бичлэгийг албан ёсны шашин хуудсаар дамжуулан түгээх.
2	Бизнес эрхлэгчдийн уулзалтад бизнес эрхлэгчдийг хамруулах	Б.Алтан Д.Ганхуяг Д.Цэцэбуяа Э.Ганзориг Н.Ганчимэг	Даваа гаригт Ойрад ХЖТ-т болох бизнес эрхлэгчдийн уулзалтад бизнес эрхлэгчдийг бүрэн хамруулах, урьга хүргүүлж, утсаар холбогдон мэдээлэл түгээх.
3	Танилцуулга/брошюр	Г.Болортуулал	Танилцуулгын загвар гаргах, Даваа гаригт гэхэд бэлэн болгох.
4	Бизнес эрхлэгчидтэй уулзаж и-бизнес платформын талаар мэдээлэл өгөх, судалгаа авах, мэдээлэл өгөх, танилцуулга тараах	Э.Наранмаадах Ц.Магнайдүүрэн Г.Тамир Э.Гончиг Т.Төвсанаа Ж.Бат-Оргил Б.Ууганболор Г.Ариунболор Ц.Бумбаяр Н.Ананд Х.Ганчимэг	Даваа гаригт зохион байгуулах бизнес эрхлэгчдийн уулзалтын үеэр танилцуулга тараах, судалгаанд хамруулах, эвлэлд цугларсан бизнес эрхлэгчид хэрэглэж судалгаа өгөх талаар заавар зохиомж өгөх, зөвлөмж өгөх буй үйл ажилын зураг дарах. Пүрэв гаригт хуваарийн дагуу бизнес эрхлэгчидтэй уулзаж эсвэл утсаар холбогдон судалгааны асуулга авч мэдээллийг google forms-т оруулах.
5	Шашин сургалт	Г.Болортуулал Э.Наранмаадах Г.Тамир Я.Хонгорзүл	Хамаа гаригт сумдын бизнес эрхлэгчид зориулсан шашин сургалт зохион байгуулах.
6	“Бизнес ба хүний эрх” шашин сургалт	Г.Болортуулал	Пүрэв гаригт болох шашин сургалтын мэдээллийг холбогдох байгууллагад албан бичгээр уламжлах, төрийн албан хамгаалт хамруулах.
7	Үйл ажиллагааны нэгдсэн тайланг дутгах	Ажлын хэсгийн гишүүд	Судалгааны үр дүнг Пүрэв гаригийн 16:00 цагт бүрэн нэгдсэн байна.
8	Тайлан нэгтгэн, холбогдох байгууллагад нэгтгэх.	С.Оюунбилэг Г.Болортуулал	Арга хэмжээний тайланг нэгтгэн холбогдох байгууллагад болон ажлын хэсгийн гишүүдэд нэгтгэх.

2. Бизнес эрхлэгчдээс авсан судалгааны асуумжийн үр дүн

252 responses

[Link to Sheets](#)



Summary


Question

Individual

Та хэдэн жил бизнес эрхэлж байна вэ?

[Copy chart](#)


237 responses



Та "И-Монголиа"-гийн талаар мэдэх үү?

[Copy chart](#)


247 responses



Та "И-Бизнес"-ийн талаар мэдэх үү?

[Copy chart](#)

245 responses



3. Зах, худалдааны төвүүд дэх бизнес эрхлэгчдээс тандалт судалгаа авч буй үйл явц



Цахим холбоос:

<https://www.facebook.com/uvs.zasag/videos/1349757289647640>

<https://www.facebook.com/uvs.zasag/videos/674703618532029>

<https://www.facebook.com/uvs.zasag/videos/1786071015665836>

4. Бизнес эрхлэгчдэд зориулсан e-business.mn платформын танилцуулга бүхий тараах материал.

business
ТОП-10 үйлчилгээ

- Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах
- Оношилгоо, техникийн хяналтын үйлэйн мэдээлэл харах
- Улс орны бүртгэл олгох үйл ажиллагаа
- Хуулийн этгээдийн дангарангүй лавлагаа
- Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсхүл тодорхойлолт
- Татварын ерийн үлдэгдлийн лавлагаа
- Засгийн газрын лавлагаа
- Автозасгийн хэрэгсэл эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа
- Ажил олгогчийн нийгмийн даатгалын шийтгэл тодорхойлолт
- Шинээр үүсгэн байгуулагдсан хэргээрлагдсан хариуцаагай компанийн үйлдлийн бүртгэл бүртгүүлэх
- Иргэний лавлагаа, тодорхойлолтыг e-business-аас авдаг бол хуулийн этгээдийн лавлагаа тодорхойлолтыг e-business-аас авдаг.

business

"E-Business.mn" систем цаашид дараах сайжруулалтын ажлуудыг хийхээр төвлөж байна.

- Хуулийн этгээд шинээр бүртгүүлэхэд шаардагддаг 34 алхмыг 35 алхам болгож бууруулна. Ингэснээр 12 хоногийг 1 хоногт буюу 2 цагт шинээр компани байгуулдаг болно.
- Арилжааны банкнуудтай хамтарч, хуулийн этгээд байгуулахдаа шууд цахимгаар данс нээх боломжийг бий болгоно.
- Нотариатад заавал бичлэн очдог байдлыг халж, хуулийн этгээд бүртгүүлэх цахимгаар тоон гарын үсэг, тамга захиалж авах боломжтой болно.
- Шинээр компани байгуулахад хуулийн этгээдийн оноосон нэрийг авах үед давхардаж байгаа эсэх, ижил төстэй нэр бүхий хуулийн этгээд байгаа эсхийг хиймэл оюунаар шалгадаг болно.

ХҮРДАН
Та ХҮРДАН цэгээс эсвэл 1111-2 лавлах дугаараас мэдээлэл авах боломжтой.

business
Та байгууллагын тоон гарын үсгээр эсвэл банкны эрхээр дамжуулан нэвтрэх боломжтой.

business
Та өөрийн "e-mongolia" аппликэйшныг уншигчиг ажиллуулж нэвтрэх боломжтой.


УБС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
e-business
танд зориулав

Хуулийн этгээдийн цахим үйлчилгээний СИСТЕМ

Энэхүү кодыг уншуулна уу.

5. Арга хэмжээний хүрээнд байгууллагын удирдлагууд, төрийн албан хаагчдад мэдээлэл хүргэж байгаа үйл явц





6. Бизнес эрхлэгчдийн уулзалт, зөвлөгөөний үеэр e-business.mn платформуос хэрхэн үйлчилгээ авах талаар зөвлөгөө мэдээлэл хүргэж буй үйл явц





7. **e-business.mn** платформын ашиглалтын явцад тулгарч буй хүндрэл, шийдлийн талаар санал солилцож буй үйл явц





Тайлан нэгтгэсэн:

Увс аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Г.БОЛОРТУНГАЛАГ